БҮЛЭГ: ХУВЬ ХҮН БА СОЁЛ
СЭДЭВ:СОЁЛ ХЭРХЭН ӨӨРЧЛӨГДДӨГ ВЭ?

Хамрах хүрээ: 8 анги

УЛААНБААТАР

2021

Багш: З. Цэвэгмиджав

Соёл нь тухайн нийгмийг бусад нийгмээс ялгах шинж, тухайн нийгмийн хөгжлийнх нь үндэс төдийгүй хүмүүс хойч үедээ өвлүүлдэг үнэт зүйл юм.

Соёл хөдөлгөөнгүй зүйл биш.

Соёл үүсч хөгжиж бас доройтолд орж нэг ард түмэн улс орноос нөгөөд түгэн дэлгэрч, өнгөрсөн үеийнхээс хойч үеийнхэнд уламжлагдан дамжин өөрчлөгдөж байдаг.

СОЁЛЫН ӨӨРЧЛӨЛТ

Соёлын өөрчлөлтөнд нөлөөлөх олон хүчин зүйл байдаг.

Шинэ бүтээл, ололт амжилт



Байгаль орчин

Соёлуудын харилцан нөлөөлөл нэвчилт

ШИНЭ БҮТЭЭЛ, НЭЭЛТ

Аливаа шинэ бүтээл нээлт бол оршин байгаа соёлыг шинэ хэлбэртэй болгодог. Жнь: 1876 онд телефон, 1903онд агаарын тээвэр бүтээсэн нь хүн төрөлхтний амьдрал соёлын хэв маяг, харилцаанд онцгой өөрчлөлт оруулсан.

СОЁЛУУДЫН ХАРИЛЦАН НӨЛӨӨЛӨЛ, НЭВЧИЛТИЙН ҮЙЛ ЯВЦ

Соёл нэг бүлгээс нөгөөд, нэг нийгмээс нөгөөд дэлгэрэх үйл явцыг соёлын нэвчилт гэдэг. Жнь: нүүдлийн соёл иргэншлээс суурин соёл иргэншилд шилжих, өндөр хөгжилтэй улсуудын хэрэглээнд байгаа зүйлсийг ашиглах....



БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛӨЛ

Хүмүүсийн амьдрал соёлын өөрчлөлтөнд байгалийн хүчин зүйл нөлөөлдөг. Жнь: Дэлхийн дулаарал, цөлжилт...

ЖИШЭЭ НЬ:

Цөлжилтөнд нэн хүчтэй зэрэглэлд өртсөн Дорноговь аймгийн замын үүд сумын зураг.

Чийг дутагдалтай буюу ууршилт нь тунадаснаасаа давуу уур амьсгалын нөхцөлтэй нутаг дэвсгэрийг ерөнхийд нь цөл гэсэн ангилалд хамруулдаг. Жилд 250мм-ээс бага хур тунадастай газар цөл үүсэх нөхцөл бүрдэж байдаг.

СОЁЛЫН ХОЖИМДОЛ

Улс үндэстний соёлд материаллаг бүтээн босголтын зэрэгцээ хүн ардынх нь ёс суртахуун гарцаагүй чухал үүрэгтэй. Гэтэл бодит байдал дээр материаллаг зүйлсэд хэт их шунах нь зарим сөрөг үр дагаварт хүргэдэг. Үүнийг соёл судлаачид соёлын хожимдол гэдэг.

Өөрөөр хэлбэл соёлын өөрчлөлтүүд заримдаа зөрчлийг дагуулдаг. Материаллаг хангамж өндөр хэрэглээнд хэт их ач холбогдол өгч, мэдлэг хүнлэг энэрэнгүй сэтгэл зэргээс илүүд үзэх явдал гардаг. Энэ нь зохисгүй байдал, буруу хэвшил сөрөг зүйлсийг дагуулдаг. Үүнийг л соёлын хожимдол гэж нэрлэж байгаа юм.

“АСУУДЛЫН МОД” ГЭСЭН АРГААР АМЬДАРЧ БУЙ НУТГИЙНХАА СОЁЛ ХЭРХЭН ӨӨРЧЛӨГДӨЖ БУЙГ ТАЙЛБАРЛАНА УУ?



Үр жимс

Их бие

Үндэс

Үр дагавар

Асуудал

Шалтгаан

ДҮГНЭЛТ

Хүний хөгжих бололцоо, орчин нь хэр хөгжсөн, хүн амын өсөлт эрүүл мэнд, амьдралын түвшин ямар байгаа, байгаль цаг уурын өөрчлөлт зэрэг үзүүлэлт нь тухайн орон нутгийн соёлын чухал үзүүлэлт болдог.

Гол ойлголтуудаа дэвтэртээ тэмдэглэж аваарай.